

Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр

ЕБС-ийн багшийн мэргэжил дээшлүүлэх курс

2019 оны Японы санхүүгийн жилд хэрэгжих Япон улсын Засгийн газар (Япон улсын Боловсрол, шинжлэх ухааны яам)-ын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах шалгалт өгөх хүсэлтэй монгол оюутнуудыг дараах шаардлагын дагуу бүртгэж байна.

1. ЕБС-ийн Багшийн мэргэжил дээшлүүлэх курс Хөтөлбөрийн танилцуулга

ЕБС-ийн үндсэн багш нарт зориулсан Япон улсын их, дээд сургуульд "Сургуулийн боловсрол"той холбоотой судалгаа хийх хөтөлбөр болно.

2019 оны 10 дугаар сараас 2020 оны 3 дугаар сар хүртэл Япон талаас хуваарилсан их дээд сургуулийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах ба тогтсон хугацааг сунгах боломжгүй. Суралцах хугацаанд сар бүр 143,000 иений тэтгэлэг олгогдоно.

2. Тааигдах шаардлага, болзол

- 1) 1983 оны 4 дүгээр сарын 2-ноос хойш төрсөн байх. /35 нас хүртэлх бөгөөд 4 сарын 2-оос хойш төрсөн байх/
- 2) Их дээд сургууль эсвэл багшийн сургууль төгссөн байх.
- 3) Монгол улсын ЕБС-д одоо үндсэн багшаар багшилж байгаа бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 1-ний байдлаар үндсэн багшаар 5 ба түүнээс дээш жил багшилсан туршлагатай байх (Их, дээд сургуулийн багш, цагийн багш, ЕБС-ийн удирдах ажилтан, япон ба англи хэлнээс бусад гадаад хэл болон монгол хэлний багшийн хувьд оролцох боломжгүй).
- 4) Япон хэлийг идэвхтэй сурах хүсэлтэй байх. Япон орныг сонирхдог бөгөөд Японд очсон хойноо өөрийн зүгээс идэвх санаачлага гарган Япон орны тухай ойлголтоо гүнзгийрүүлэх хүсэлтэй байх. Мөн Японд судалгааны ажилд оролцож, Японд амьдрах чадвартай байх.
- 5) **Япон хэлний түвшин шалгаруулах шалгалтын N3-аас дээш эсвэл TOEFL iBT 60-аас дээш байх**
- 6) Монгол улсын иргэн байх.
- 7) Бие болон сэтгэцийн хувьд эрүүл байх.
- 8) Японы их сургуулиас заасан хугацаанд Японд очих боломжтой байх.
- 9) Японд очихдоо "Их дээд сургуулийн оюутан" ангиллын виз авах
Японд очсоныхоо дараа визнийхээ ангиллыг сольсон тохиолдолд цаашид тэтгэлэг авах эрх хасагдахыг анхаарна уу.
- 10) Цэргийн албан хаагч шалгалт өгөх боломжгүй.

- 11) Урьд нь Япон улсын Засгийн газрын ямар нэг тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаагүй байх.
- 12) Одоогоор Японд суралцаж байгаа эсвэл тус хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө Японд суралцахаар төлөвлөж байгаа бол энэ шалгалтыг өгөх боломжгүй. Одоогоор Японд суралцаж байгаа боловч тус хөтөлбөр хэрэгжиж эхлэх хугацаанаас өмнө сурч дуусаад Монголд буцаж ирэх нь тодорхой бол энэ шалгалтыг өгөх боломжтой.
- 13) Өөр ямар нэг шугамаар тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж байгаа буюу хамрагдах гэж байгаа бол, мөн Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн бусад төрлийн шалгалтыг давхар өгөх гэж байгаа бол энэ шалгалтыг өгөх боломжгүй.

3.Бүртгэл

Дээрх нөхцөл, шаардлагыг сайн уншиж танилцсаны үндсэн дээр шаардлага хангах материалаа өгөн бүртгүүлнэ үү. Материал дутуу бол бүртгэхгүй.

Хэзээ: 2019 оны 1 дүгээр сарын 23-наас 25-ны өдрүүдэд 13:00-17:00 цагт

Хаана: Монгол-Японы төв

Бүрдүүлэх бичиг баримт

1. Иргэний үнэмлэх (эх хувийг үзээд буцааж өгнө)
2. Сүүлийн 6 сарын дотор авахуулсан, 3.5x4.5 см хэмжээтэй, эгц өөдөөс харсан, нүүр царай тод гарсан, малгайгүй цээж зураг 2 хувь.
3. Ажлын газрын тодорхойлолт (5 ба түүнээс дээш жил үндсэн багшаар ажиллаж буйг баталсан)
4. Төгссөн их сургуулийн диплом (эх хувийг үзээд буцааж өгнө)
5. Япон хэлний түвшин тогтоох шалгалтын оноо эсвэл ТОЕФЛ-ийн оноо
6. Нийгмийн даатгалын дэвтэр (эх хувийг үзээд буцааж өгнө)

Шалгалт

А. Бичгийн шалгалт : Япон хэл, Англи хэл

Хэзээ: 2-р сарын 24-ний өдөр (Ням)

Хаана: Монгол-Япон төв, эсвэл МУИС-ийн 2 дугаар байр /Жич зарлана/

Шалгаруулалтын хариу гарах тов: 2-р сарын 25-ны өдөр (Даваа)

Бүрдүүлэх материалыг тайлбарлах: 2-р сарын 26-ны өдөр (Мягмар) Монгол Японы төвд (Зөвхөн шалгалтанд тэнцсэн хүмүүст хамааралтай)

Б. Ярилцлагын шалгалт:

Бичгийн шалгалтад тэнцсэн хүмүүсээс ярилцлагын шалгалт авна. Ярилцлагын шалгалт хэзээ авах талаар бичгийн шалгалтанд тэнцэгсдэд жич мэдэгдэнэ.

※Ярилцлагын шалгалтанд тэнцсэн гэдэг нь хамгийн эцсийн хариу биш бөгөөд Японы БСШУСЯ-аас эцсийн хариуг 7 сард зарлана.

Мэдээлэл: https://www.mn.emb-japan.go.jp/itpr_mn/culture181218.html